

ГАЗАРЗҮЙН ДИДАКТИКТ ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Е.Батчулуун, профессор
МУБИС-ийн МБУС-ийн Газар зүйн тэнхимийн багш
Г.Уранчимэг
Математик Байгалийн Ухааны Сургалт Арга зүйн тэнхимийн багш
П.Энхжаргал
Газар зүйн тэнхимийн багш

Abstract: The goal of teaching practice is to revise how didactics theory and methodology, psychology, pedagogy and theoretical knowledge and skills have been applied and used in practice, how pedagogical and teaching skills have been acquired, and how research methods have been learnt. Therefore, quality and results of teaching practice essentially influence on the teacher training.

This study was aimed at finding out the vital issues related to the teaching, training and didactics of geography based on the research and observation at the student-teaching practice which was done by the third year students of Geography Department, School of Mathematics and Natural Sciences, MNUE in 2014-2015. The 98 student-teachers who did practice in 19 schools in Ulaanbaatar and 9 in the rural areas such as Dundgobi, Khentii, Sukhbaatar, Uvurkhangai, Arkhangai, Bulgan, Darkhan-Uul, Selenge and Tuv were involved in this survey.

Түлхүүр үг: шинжлэх ухаанч арга барил, кейсээр дамжуулан судлах арга, сургалтын орчин

Удиртгал

Багшийн мэргэжлээр суралцах оюутны сургалтын төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бол багшлах дадлага бөгөөд энэ нь МУБИС байгуулагдсан үеэс эхлэлтэй юм. Багшлах дадлага хийх журам ба сургалтын төлөвлөгөөнд заасны дагуу

өнөөдөр МУБИС-ийн оюутнууд хоёр шатны дадлагыг, нийслэл болон хөдөө орон нутагт явуулж байна. Энэхүү өгүүлэлд МБУС-ийн Газарзүйн тэнхимийн эрхлэгч Х.Цогбадрал, багш С.Хадбаатар, Ц.Бат-Эрдэнэ, А.Амгалан, Ц.Сэр-Од нарын судалгааны баримтыг ашигласан болно.

БШУЯ-наас боловсролын чанарын шинэчлэлийн бодлого дэвшүүлж, 2013 оныг “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, арга зүй, технологийн жил” болгон зарласан. Үүнтэй холбогдуулан МУБИС ч багшлах дадлагаа шинэчлэх зорилт дэвшүүлж, энэ ажлын хүрээнд оюутнуудыг хөдөө орон нутагт дадлага хийлгэж, БШУЯ-аас тэтгэлэг олгодог болсон нь оюутнуудын идэвх, сурлагын өрсөлдөөнийг өрнүүлсэн төдийгүй тэдний хөдөө орон нутагт ажиллах сонирхлыг төрүүлсэн үр дүнтэй ажил болж байна.

МУБИС-ийн ректорын 2003 оны 76 тоот тушаалаар тухайн оноос эхлэн мэргэжлийн ур чадвараар тэргүүний багш нарыг сургалтад хамруулан “клиник профессор” болгож, хамтран ажилласаар ирсэн нь ЕБС-ийн багш нар, сургуулиуд дадлага хүлээж авах сонирхолтой болох, дадлагын чанарыг сайжруулахад зохих хувь нэмрээ өгсөн юм.

Багшлах дадлагын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд оюутнуудын дунд “Багшлах ур чадварын олимпиад”-ыг жил бүр зохион байгуулж, шилдэг арга зүйч, зохион байгуулагч, судлаач оюутан



ба дадлагын ажлыг сайн удирдсан сургуулиудыг шалгаруулахын хамт ЕБС-ийн дадлага удирдаж байгаа багш нарын ажлын хөлсийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Энэ нь оюутны онол, практикийг хослуулах чадварыг нь сайжруулах, туршлага ололт амжилтаа солилцох, сургалтын чанар үр өгөөжид үнэлэлт дүгнэлт хийж цаашдын үйл ажиллагааг төлөвлөхөд нь ач холбогдлоо өгдөг. Мөн дадлага удирдсан ЕБС-ийн багш нарын үүрэг хариуцлагыг сайжруулахаас гадна дадлага авах сонирхлыг төрүүлж байна.

Хэдийгээр жил бүр багшлах дадлага зохион байгуулж, түүнийг шинэчлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа ч бидний өмнө багшлах дадлагатай холбоотой олон тулгамдсан асуудлууд байсаар байна. Үүнийг тодорхой судалгаанд үндэслэн тодруулж, цаашид авах арга замыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

Судалгааны зорилго: Газар зүйн дидактикт тулгамдаж буй зарим асуудлуудыг илрүүлж, шийдвэрлэх арга замын талаар санал боловсруулахад судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилт:

- МУБИС-д багшлах дадлага явуулж ирсэн байдал, МУБИС-ийн оюутны сурган хүмүүжүүлэх дадлагатай холбогдох бичиг баримтын судалгаа хийх
- Багшлах дадлагын явцад ажиглалт судалгаа хийх, дүнг нэгтгэх
- Дадлагын үед тулгарсан бэрхшээл ба сургалтын орчин, сурах бичиг, сургалтын арга зүйн талаар асуулга судалгаа авч, үр дүнг нэгтгэн боловсруулах

Бичиг баримтын судалгаа болон ажиглалт асуулгын үндсэн дээр газар зүйн дидактикт тулгарч буй зарим асуудлыг судалж тогтоох

Арга зүй

Баримтын судалгаа, сургалтын явцад хийсэн анализ, асуулгын арга, ярилцлагын арга (бүлгийн ярилцлага), математик ба статистик боловсруулалтын арга

Үр дүн

1. Улаанбаатар хотын 19, Булган (1-р сургууль, Могод, Гурванбулаг, Дашинчилэн) ба Сэлэнгэ (Баруунбүрэн) аймгийн 5 сургуулийн нийт 45 цагийн газарзүйн хичээлд сууж ажиглалт судалгаа хийсэн байдлыг нэгтгэж үзэв (Хүснэгт 1)

Хүснэгт 1


Хичээлд хийсэн судалгааны шалгуур үзүүлэлт /цагаар/

Анги	VII	VIII	IX	X	XI	XII	Нийт
Ажиглалт хийсэн хичээлийн тоо	6	6	7	6	8	12	45
Шинжлэн судлах аргад тулгуурлах (туршилт хийх)	3	2	-	2	1	-	8
Асуудал шийдвэрлэхэд тулгуурлах	3	3	2	2	-	-	10
Кейсээр дамжуулж судлах аргад тулгуурлах	-	-	-	1	-	1	2
Уламжлалт арга барил давамгайлах	4	4	4	4	4	5	25
Бие даах үйл ажиллагааг хэрэгжүүлэх	3	2	3	2	2	4	16
Багаар ажиллах	4	3	3	3	2	5	20

Сурах бичгийн зураг, график, диаграмм, дасгал даалгавартай ажиллах	3	2	1	1	1	3	11
Газарзүйн зураг, хэрэглэгдэхүүн ашиглах	5	4	6	4	4	8	31
Хэмжилтийн багаж, хэрэгсэл ашиглах	2	-	-	2	-	-	4
Мэдээлэл харилцааны технологи (МХТ) ашиглах	4	4	6	5	6	10	35

Сонгож ажиглалт хийсэн нийт 45 цагийн хичээлийн судалгаанаас үзэхэд 25 цаг буюу 56 хувийг багш мэдээллийг дамжуулах уламжлалт аргаар олгож байсан бол орчин үеийн хичээлд тавигдаж буй шинэлэг арга зүйг хэрэгжүүлэх хандлагатай хичээл 44 хувь байна. Энэ нь ихэнх хичээлийг уламжлалт аргаар зааж байна гэж үзэж болохоор байна. Туршилт явуулж, шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэхэд чиглэсэн хичээл нийт хичээлийн 18 хувь, асуудал шийдвэрлэхэд тулгуурласан нь 22 хувь, кейсээр дамжуулж судлах аргад тулгуурласан нь 4 хувь тус тус эзэлж байна (Зураг 1). Эндээс үзвэл 12 дугаар ангийн сурах бичигт байгаа “кейс судлах” элементийг ашиглахгүй байгаа нь судалгаанаас харагдсан бөгөөд “кейсээр дамжуулж судлах арга”-ыг оюутан-багш нар ойлгоогүйтэй холбоотой гэж бид үзлээ.

Диаграмм 1
Хичээлд ашигласан сургалтын арга зүй



Диаграмм 2
Хичээлд хийсэн судалгааны шалгуур үзүүлэлт



Эндээс хэдэн онцлог элементийг сонгон авч дүгнэлт хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Сурах бичгийн зураг, график, диаграмм ба дасгал даалгавар, мөн хэмжилтийн багаж хэрэгслүүдийг хичээлд ашиглах явдал бага, харин газарзүйн зураг, проектор ашиглан дэлгэцийн үзүүлэн ашиглах нь харьцангуй өндөр байна гэж үзэх үндэстэй бөгөөд энэ нь судалгаанд хамруулсан нийт хичээлийн 78 хувьд нь газарзүйн зураг, 80 хувьд нь цахим хэрэглэгдэхүүн хэрэглэсэн байдлаас харагдаж байна (Зураг 2). Гэвч эдгээр хичээлийн явцаас харахад ихэнх нь мэдээллийн хэрэгслийг мэдлэг бүтээхэд биш, харин мэдээллийг шууд дамжуулахад л зориулан ашиглаж байна.
- Сургалтын гол хэрэглэгдэхүүн болсон газарзүйн зургийг сургалтад ашиглах явдал төдийлэн хангалттай бус байна гэж бид дүгнэж байна. Учир нь сургалтын хэрэглэгдэхүүн ашиглалт нь зөвхөн ханын зургаар л хязгаарлагдаж, зурагзүйн бусад бүтээлүүдтэй ажиллах явдал тун хангалтгүй, түүнчлэн зургийг харьцуулж дүгнэлт



гаргах, зургаас мэдээлэл боловсруулах зэрэг бүтээлч үйл ажиллагаа бага байгаа нь харагдлаа.

- Хэмжилтийн багаж, хэрэгсэл ашиглах байдал 16 хувь буюу хамгийн бага үзүүлэлттэй гарч, энэ нь ЕБС-д хэмжилтийн багаж, хэрэгсэл үндсэндээ байхгүй байгааг харуулж байна.

2. Нийслэл хот болон хөдөө орон нутагт багшлах дадлага хийсэн 98 оюутан-багшаас авсан асуулга ба ярилцлагын дүнгээс үзвэл судалгаанд хамрагдсан нийт оюутны 63,3 хувь нь газарзүйн кабинет байхгүй гэсэн бол цаг агаарын ажиглалтын талбайтай сургууль байгаагүй гэж бүгд хариулсан байна (Хүснэгт 2). Энэ нь ЕБС-ийн газарзүйн сургалт зориулалтын анги танхимд явагддаггүй, сургалтын орчин хангалттай бус байгааг харуулж байгаа юм.


Хүснэгт 2

Газарзүйн сургалтын орчин ба хэрэглэгдэхүүний хангамжийн байдал

Газарзүйн сургалтын орчин ба хэрэглэгдэхүүн	Судалгаанд оролцсон оюутны тоо		
	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй
Газарзүйн кабинет	36	-	62
Цаг агаарын ажиглалтын талбай	-	-	98
Газарзүйн зураг	18	49	31
Глобус	6	19	73
Монгол орны атлас	27	31	40
Дэлхийн атлас	3	18	77
Хэмжилтийн багаж	11	19	68
Проектор	18	14	65
Багшийн ном	18	32	48
Сурах бичиг	68	26	4


Диаграмм 3

Газарзүйн сургалтын орчин ба хэрэглэгдэхүүний хангамж (хувиар)



Диаграмм 4

Сургалтад ашиглагдсан ном, сурах бичгийн судалгаа




Сургалтад хамгийн их хэрэглэгдсэн ном, сурах бичиг, гарын авлага юу байсан бэ? гэсэн асуултад нийт оюутны 73 хувь нь сурах бичиг гэж хариулсан нь сурагчдад зориулсан сурах бичгийг багш нар гарын авлага болгож хэрэглэдэг сэтгэлгээ хэвээр байгааг нотлон харуулж байна (Зураг 4). Нөгөөтэйгүүр багшийн номын хангамж муу байгаа нь ч ийм нөхцөл байдал үүсэхэд хүргэж байгаа юм.

Хичээл заахад тулгарсан бэрхшээл юу байсан бэ? гэсэн асуултад нийт оюутны 88.8 хувь нь хэмжилтийн багаж хэрэгсэл байхгүй, 72,5 хувь нь газарзүйн зураг, атлас хүрэлцээгүй, 49 хувь нь сурагчдын суурь мэдлэг муу, 47 хувь нь багшийн ном олдохгүй гэсэн бэрхшээлүүдийг тус тус нэрлэжээ (Зураг 5). Энэ нь газарзүйн сургалтын материаллаг орчин ба хэрэглэгдэхүүний хангамж муу байгаатай холбоотой байна. Жишээ нь: 10 дугаар ангид “Агаарын чийг тунадас” гэсэн сэдвийн хүрээнд шүүдэр цэг болон ангид байгаа агаарын харьцангуй чийгийг хэмжих хялбар туршилт сурах бичигт байгаа боловч түүнийг хийлгэх термометр сургуулийн хэмжээнд огт байхгүй байсан.

Диаграмм 5

Хичээл заахад тулгарсан бэрхшээл



ДҮГНЭЛТ

1. Оюутан багш нь ЕБС-ийн сурах бичиг ба багшийн номтой сайн ажиллахгүй байна. Сурах бичиг сурагчдад зориулагдсан атал багш нар хэрэглэж, ингэхдээ сурах бичиг дэх үндсэн текстийг хуулуулж бичүүлэхээс хэтрэхгүй, түүн дээрх дасгал даалгавар, туршилт, зураг, график диаграмм зэрэгтэй нь сурагчдыг ажиллуулахгүй байна. Энэ нь нэгдүгээрт, “мэдээлэл дамжуулж” ирсэн уламжлалт заах арга өнөөг хүртэл бат бөх оршоор байгаатай, хоёрдугаарт, багш-оюутнууд хичээл бэлтгэх явцдаа өөрсдөө хийж гүйцэтгэдэггүйтэй, харин гуравдугаарт, оюутан-багш нар өөрсдөө сурах бичгээ сайн



- ойлгоогүй ба тэдний онолын мэдлэг нь дутмаг байгаатай холбоотой гэж үзэж байна.
2. ЕБС-д одоо хэрэглэгдэж байгаа сурах бичгийн агуулга, дидактик тавил нь шинжлэх ухаанч арга барилд сургахад нийцэхгүй байна. Иймд сурах бичиг болон багшийн ном, мөн холбогдох гарын авлага, зураг атлас зэргийг бичиж хэвлүүлэх ба сургалтад хэрэглэхэд тэнхим, сургуулийн зүгээс ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэй байна.
 3. Газарзүйн сүүлийн үеийн сурах бичигт нэлээд туршилтууд орсон байгаа ч хичээл дээр туршилт хийлгэдэг багш тун цөөн байна. Үүнд, олон шалтгаан нөлөөлж байгаа ч хамгийн гол нь туршилтад бэлтгэх нь багшид төвөгтэй, ангид байх хүүхдийн тоо олон, туршилт хийх багаж төхөөрөмж байхгүй зэрэг шалтгаан нөлөөлж байна. ЕБС-ийн газарзүйн хичээлээр хийх туршилтын сан байгуулах, шинэ сурах бичигт мөн тийм туршилтыг оруулах шаардлагатай байна.
 4. Газарзүйн сургалтыг сайжруулах ба шинжлэх ухаанч арга барилд тулгуурлан явуулахын тулд хичээлд хэрэглэх багаж төхөөрөмжөөр хангах асуудлыг ЕБС-дад нэгдсэн байдлаар шийдвэрлэх (цаг агаар, хөрс, усны хэмжилтийн багажууд, сургалтын газарзүйн зураг, атлас г.м) шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Батсүх, Г., ба бусад. (1982). *Ерөнхий боловсролын дунд сургуульд газарзүй заах арга*. Улаанбаатар
- Батчулуун, Е., ба бусад. (2015). Шинжлэх ухаанч арга барилыг газарзүйн хичээлд хэрэглэх боломжийг туршсан зарим үр дүн. Улаанбаатар
- Жамбалдорж, Т., ба бусад. (2011). *Зуун өртөөлсөн нэгэн жаран*. Улаанбаатар
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2014). *Сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх журам, гэрээ, маягт тушаалууд (37-41)*. Улаанбаатар: МУБИС-ийн Press Edu.
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2015). *Математик, Байгалийн Ухааны дидактикийн тулгамдсан асуудал, шийдэл, арга зам эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл*.
- Содномваанчиг, Г. (2000). *Газарзүйн хичээлийн технологийн шинэчлэл*. Улаанбаатар
- Абасов.З.А., Роль педагогической практики студентов в их профессиональном становление. 2002. www.Ecsocman.hse.ru/data/010/992/1219/013.ABASSOV.pdf-aac
- МУБИС-д мөрдөх дүрэм, журмын эмхтгэл. 2015.03.14. www.msue.edu.mn/doc/MUBIS.docx-aac.
- МУБИС-ийн Түүхт 60 ЖИЛ-ийн товчоон, 2015.03.11. <http://msue.edu.mn/>-аас.
- Оюутнуудад багшлах дадлагын тэтгэлэг олгодог болно. 2013.02.18. <http://www.news.mn/content/134394.shtml-aac>.